



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 608

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2, 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 36 нэрийн, нийт 19,518,228.44 (арван есөн сая таван зуун арван найман мянга хоёр зуун хорин найман төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 8,445,000.00 (найман сая дөрвөн зуун дөчин таван мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132006972

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ
ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	ндсэн хөрөнгийн нэр, мар	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Тоо шир хэг	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа (жилээр)
					Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Сандал	8/23/2019	525,000.00	35	8,000.00	280,000.00	2
2	Сандал	12/30/2019	1,050,000.00	50	13,000.00	650,000.00	2
3	Сандал /сургалтын/	11/12/2018	766,500.00	15	22,000.00	330,000.00	3
4	Сандал /заалны/	12/30/2019	3,465,000.00	77	22,000.00	1,694,000.00	3
5	Сандал /хар/	12/30/2019	313,500.00	33	8,000.00	264,000.00	3
6	Сандал /рапорт/	12/26/2017	1,662,025.00	5	120,000.00	600,000.00	3
7	Сейф	8/23/2019	9,333.44	1	50,000.00	50,000.00	3
8	Сейф	8/23/2019	40,000.00	1	50,000.00	50,000.00	3
9	Хивс /3*4 хэмжээтэй/	8/23/2019	180,000.00	1	80,000.00	80,000.00	3
10	Хивс /улаан/	8/23/2019	1,041,250.00	5	50,000.00	250,000.00	3
11	Хурлын индэр	5/2/2018	164,520.00	3	35,000.00	105,000.00	3
12	Хурлын урт ширээ	5/2/2018	222,400.00	1	85,000.00	85,000.00	3
13	Шилэн шкаф	12/28/2017	440,000.00	1	100,000.00	100,000.00	3
14	Ширээ /сургалт/	11/12/2018	766,500.00	15	13,000.00	195,000.00	3
15	Ширээ /шар/	12/30/2019	180,000.00	1	50,000.00	50,000.00	3
16	Ширээ /шар/	6/30/2012	1,212,200.00	29	25,000.00	725,000.00	3
17	Шкаф /төмөр/	12/30/2019	150,000.00	2	40,000.00	80,000.00	3
18	Шкаф	12/30/2019	190,000.00	1	80,000.00	80,000.00	3
19	Хөргөгч	12/26/2017	719,900.00	1	450,000.00	450,000.00	3
20	Зурагт /TOSH-43I/	12/26/2017	999,900.00	1	450,000.00	450,000.00	3
21	Жигнүүр /буузны 3 давхар/	12/30/2019	170,000.00	2	40,000.00	80,000.00	2
22	Махны машин	12/30/2019	145,000.00	1	65,000.00	65,000.00	2
23	Печь /веко дээрээ ширэмтэй/	12/30/2019	155,000.00	1	60,000.00	60,000.00	2
24	Принтер /sams-sxc-3200/	12/30/2019	100,000.00	2	30,000.00	60,000.00	2
25	Принтер /samsung 1670/	12/30/2019	50,000.00	1	30,000.00	30,000.00	2
26	Компьютер /Aser/	12/30/2019	330,000.00	1	160,000.00	160,000.00	2
27	Компьютер /Dell I7/	12/30/2019	650,000.00	1	160,000.00	160,000.00	2
28	Компьютер /Dell DT/	12/14/2016	1,399,800.00	1	500,000.00	500,000.00	3
29	Компьютер /Aser/	8/24/2016	1,069,600.00	1	160,000.00	160,000.00	3
30	Лед самбар /16*192/	12/31/2018	380,000.00	1	100,000.00	100,000.00	3
31	Суурин станц	12/30/2019	90,000.00	1	50,000.00	50,000.00	3
32	Ус цэвэршүүлэгч	12/31/2018	424,900.00	1	250,000.00	250,000.00	3
33	Утасны аппарат	12/28/2017	16,900.00	1	12,000.00	12,000.00	3
34	Хуушуурын тогоо	12/30/2019	95,000.00	1	35,000.00	35,000.00	2
35	Цаас устгагч	12/30/2019	69,000.00	1	30,000.00	30,000.00	3
36	Программ /нярав/	2/2/2017	275,000.00	1	125,000.00	125,000.00	3
Нийт дүн			19,518,228.44 (Арван есөн сая таван зуун арван найман мянга хоёр зуун хорин найман төгрөг дөчин дөрвөн мөнгө)			8,445,000.00 (найман сая дөрвөн зуун дөчин таван мянга)	